



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 14 одор

Дугаар A/54

Мандалговь

“Чатбокс-108” сарын аян  
зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн өрөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1.4, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтооюур батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.1.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн тусламжийн утас-108, Чатбокс үйлчилгээг сурталчлах сарын аяныг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяны үйл ажиллагаанд шаардагдах 1 807 600 (Нэг сая найман зуун долоон мянга зургаан зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн булэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсувд), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дунг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсувд)-д даалгасугай.



0820070004  
9034137 СБТ11714

481190109